


“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ

Дугаар 5 2022 оны 2-р сар

УУРХАЙН ХААЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Уурхайн хаалтыг цогц байдлаар төлөвлөж хэрэгжүүлэх нь Монгол улсын хувьд харьцангуй шинэ туршлага тул оролцогч талууд хаалтын менежментийн талаар нэгдсэн ойлголтоо бэхжүүлэх нь нэн чухал.

Дэлхийн олон улс оронд аливаа уурхай татан буулгах, нөхөн сэргээх, бохирдлыг саармагжуулах, газар чөлөөлөх зэрэг хаалтын менежментийн арга хэмжээг төслийн эхний үе шатнаас төлөвлөж, батлуулах эрх зүйн зохицуулалтыг мөрдүүлдэг. Тухайлбал, Канад улсын Алберта мужид уурхайн компаниуд газар хөндөхийн өмнө буюу ашиглалтын зөвшөөрөл хүсэх үедээ эрх бүхий байгууллагуудад хаалтын урьдчилсан төсөөллийг хүргүүлж батлуулсан байхыг шаарддаг байна. Ингэснээр, зөвшөөрөл өгөх эрх бүхий албан хаагчид хаалтыг хууль журмын дагуу хэрэгжүүлэх, тодорхойлсон газар ашиглалтын дагуу нөхөн сэргээж, эцсийн хэрэглэгчдэд хүлээлгэн өгөх уг компанийн санхүүгийн болон техникийн чадавхыг үнэлэх боломжийг олгодог. Хаалтын төлөвлөлтийг анхнаас нь сайтар боловсруулан, уурхай ашиглалтын төлөвлөгөөнд өөрчлөлт орох тухай бүрд нь шинэчлэн, нэмэлт өөрчлөлтийг батлуулж байх ёстой.

Олон улсын Уул уурхай ба металлургийн зөвлөлөөс эрхлэн гаргасан “Уурхайн хаалтын тэргүүн туршлага” гарын авлагад танилцуулсан уурхайн хаалтын схемийг үзүүлж байна. Хаалтын менежментийг төлөвлөгөө боловсруулахаас эхлээд газар чөлөөлж, хүлээлгэн өгөх хүртэлх уурхайн амьдралын мөчлөгийн бүх үе шатуудаар уг зурагт тоймлон харуулжээ.

Зураг 1. Уурхайн хаалтын менежментын үе шатууд



Салхитын ордын өнөөгийн батлагдсан нөөцийг үндэслэвэл уурхай ашиглалт цаашид 10 орчим жил үргэлжлэх төлөвтэй байна. Хаалтын менежментийн жишиг төлөвлөгөө боловсруулахад MERIT төсөл “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-тай хамтран ажиллаж байна. Үүнд уурхайг татан буулгах, газрыг нөхөн сэргээх, бохирдол саармагжуулах болон нөхөн сэргээлтийн хяналт-шинжилгээ хийх зэрэг арга хэмжээг нарийвчлан төлөвлөж, эрх бүхий байгууллагад батлуулахаар хүргүүлнэ. Уурхай ашиглах төлөвлөгөөнд томоохон өөрчлөлт орох тохиолдол бүрд (баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг өргөтгөх, шинэ ухаш үүсгэх, нэмэлт хаягдлын сан байгуулах гэх мэт) хаалтын менежментийн төлөвлөгөөг шинэчлэн батлуулах шаардлагатай.

MERIT төсөл яагаад “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн Салхитын хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулахад техник туслалцаа үзүүлж байна вэ? Олон улсын Уул уурхай ба металлургийн зөвлөл (ICMM)-өөс гаргасан зөвлөмжийн дагуу “Уурхай ашиглах төлөвлөлттэй уялдуулан хаалтын менежментийг хэрэгжүүлэх нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, нийгэм-эдийн засгийн шилжилт, байгаль хамгаалал ба нөхөн сэргээлт, хууль тогтоомжийн хэрэгжилт, компанийн засаглал, хүний нөөц зэрэг хүчин зүйлсийг оновчтой удирдах эрэг үр дүнг бий болгодог байна” (ICMM, 2019, х.9). Уурхайн төслийг батлах эхний үе шатнаас эхлэн уурхайн хаалтыг төлөвлөх нь тухайн компани болон нутгийн иргэдийн хувьд эдийн засаг, нийгмийн үр нөлөөг нэмэгдүүлэх, зардал санхүүг үр дүнтэй төлөвлөх, уурхайн үүрэг хариуцлагыг сайжруулахад ач холбогдолтой. Монгол улсын Засгийн Газар уурхайн хаалтын хэрэгжилтэд ихээхэн ач холбогдол өгч, Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд холбогдох зохицуулалтуудыг оруулахаар ажиллаж байна.

САЛХИТЫН ОРДЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ СУДАЛГАА


Салхитын ордын байгаль орчны суурь мэдээлэлд дүн шинжилгээ хийж, судалгааны дүнг оролцогч талуудад 2 дугаар сарын уулзалтаар танилцуулав. Салхитын уурхай эхлэхийн өмнөх байгаль орчны төлөв байдал болон холбогдох тайлангуудад хавсаргасан орчны хяналт шинжилгээ, мониторингийн үр дүнг харьцуулсан бичиг баримтын судалгааг гүйцэтгэлээ. Энэхүү тойм судалгаа нь байгаль орчны төлөв байдлын сууь мэдээллийн сан үүсгэх, цаашид нэмж гүйцэтгэх шаардлагатай судалгааг тодорхойлж, дүгнэлт гаргах, төслийн 2-р үе шатанд нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулахад ашиглах зорилготой.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, Байгаль орчны аудитын тайлан, Газрын төлөв байдал, хянан баталгаа, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр зэрэг 2016-2021 оны хооронд хийгдсэн тайлан баримт бичгүүдийг хамруулан Монгол Улсын холбогдох стандартуудын шаардлагад нийцэж буй эсэхийг үнэлж, дүн шинжилгээ хийсэн.

Тайлангаар төслийн байгаль орчны төлөв байдал, уурхайн дэд бүтэц, орон нутгийн байгаль, цаг уурын мэдээлэл зэргийг үнэлэв. Үүнд:

- Хөрс, ургамалжилт, зэрлэг амьтны зэрэг байгаль орчны суурь мэдээлэл
- Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилт, агаар болон дуу чимээний бохирдлын мониторингийн үзүүлэлтүүд
- Газрын доорх усны чанар
- Хөрсний бохирдол
- Хаягдлын сангийн мониторингийн үзүүлэлтүүд

Түүнчлэн уурхайн эдэлбэр, дэд бүтэц, барилга байгууламжуудын байршил бүхий сансрын зураглал боловсруулсан. Судалгааны тайлангаас дараагийн шатанд харгалзан үзэх шаардлагатай доорх зөвлөмжүүдийг санал болгов. Үүнд:



Салхитын уурхайн агаарын зураг

- Уурхайн хаягдал овоолго болон хаягдлын сангийн физик, химийн шинж чанарыг тодорхойлох дээж авч, үр дүнг нөхөн сэргээлтийн төлөвлөлтөд ашиглах
- Агаар, хөрс, ус зэрэг байгаль орчны төлөв байдлын суурь нөхцөлийг баримтжуулах нэмэлт дүн шинжилгээ хийх
- Нөлөөлөлд өртөхийн өмнөх ургамлын бүрхэвчийн судалгааг нарийвчлан хийж, нөхөн сэргээлтэд ашиглах боломжтой нутгийн ургамлын төрөл зүйлийг тодорхойлох
- Шимт хөрсний үржил шимийн үзүүлэлт болох физик, химийн шинж чанарыг тодорхойлох дээж судалгаа хийж, нөхөн сэргээлтийг төлөвлөх, дахин ургамалжуулах аргачлал боловсруулахад ашиглах
- Төслийн эрсдэлийн үнэлгээг хийхэд шаардлагатай мэдээллээр хангах. Түүнчлэн цаашид хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулахад нэмэлтээр гүйцэтгэх шаардлагатай мэдээлэл, судалгааг тогтоох. 2022 оны 5 ба 6 дугаар сард хийхээр төлөвлөж буй уурхайн талбайд хийх дээж судалгааны байршил, төрөл ба шинжилгээний төрлүүдийг тодорхойлох.

САЛХИТЫН ОРДЫН ХААЛТЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ ТОДОРХОЙЛОХ ЭЭЛЖИТ УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хаалт, нөхөн сэргээлтийн зорилго, зорилт тодорхойлох ажлын хэсгийн эхний уулзалтыг 1 дүгээр сард зохион байгуулснаас хойш нийт 7 удаагийн Оролцогч талуудын уулзалт хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлгээр оролцогч талуудаас тодорхойлсон зорилго, зорилтын боломжит хувилбаруудыг ICMM- ын шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх, эрэмбэлэх цахим судалгааг тус тус зохион байгууллаа. Цахим судалгааны үр дүнг танилцуулах уулзалт хэлэлцүүлгийг 2-р сарын 15-нд зохион байгуулж, Зөвлөхийн багаас боловсруулсан зорилго, зорилтуудыг танилцуулж, санал нэгдэв. Үүнд:

Зорилго 1: Нөлөөлөлд өртсөн талбайг байгалийн унаган төрхөд ойртуулж, нутгийн иргэдийн уламжлалт газар ашиглалтад нийцүүлэн нөхөн сэргээх.

Зорилго 2: Уурхайн дэд бүтцийг түшиглэн орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх.



Зорилго, зорилтуудыг боловсруулах оролцогч талуудын IV ба V уулзалт хэлэлцүүлэг

Оролцогч талуудын 2-р сарын 16-нд хийсэн уулзалтаар дээрх хоёр зорилгын хүрээнд холбогдох зорилтуудыг нарийвчлан боловсруулж, хоёр дах удаагийн цахим судалгаагаар эрэмбэлж, санал нэгдэв. Хаалтын менежментийн үндсэн зарчмууд болох аюулгүй байдал, физик, химийн тогтвортой байдал, нийгэм эдийн засгийн шилжилт, экологийн үр өгөөж, тогтвортой байдал зэрэг хүчин зүйлүүдээс нөхөн сэргээлтийн үр дүн шууд хамаардаг (ICMM, 2019). Хаалтын зорилго, зорилтуудыг эдгээр зарчмуудыг мөрдлөг болгох нь нэн чухал.

Ийнхүү 2-р сарын 15, 16-ны уулзалт, хэлэлцүүлэгт Эрдэнэс Силвер Ресурс ХХК, УУХҮЯ, БОАЖЯ, АМГТГ, Усны газар, Дундговь аймгийн ЗДТГ, тус аймгийн харьяа агентлагууд, Гурвансайхан сумын ИТХ, тус сумын ЗДТГ, Чулуут багийн иргэд зэрэг нийт 30 гаруй төлөөлөл оролцож, санал зөвлөлдөв.



Оролцогч талууд Салхитын уурхайн талбайд зочиллоо



Майк Поссенте, Техникийн ахлах зөвлөх (MBA, RPFT) болон Женнифер Адамс, MERIT төслийн захирал

Салхитын уурхай болон Мандалговь хотод 2-р сарын 23, 24-нд зохион байгуулсан хэлэлцүүлгээр нөхөн сэргээлтийн зорилтуудыг эцэслэн тодорхойлж, санал нэгдэв.

ДАРААГИЙН АЛХМУУД:

Энэ 3 дугаар сард хаалт, нөхөн сэргээлтийн зорилго, зорилтуудыг эцсийн байдлаар Эрдэнэс Силвер Ресурс ХХК болон холбогдох талуудад хүргүүлнэ. Түүнчлэн хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах чухал бүрэлдэхүүн болох Эрсдэлийн үнэлгээг хийнэ.

Эх сурвалж: https://www.icmm.com/en-gb/guidance/environmental-stewardship/integrated-mine-closure-2019